

**ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ  
ТООЦОЖ ЗАРЛАХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Төв банк (Монголбанкны) тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хуулийн холбогдох заалтын дагуу Монголбанкнаас төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг тооцож зарлах аргачлалыг тодорхойлох, хяналт тавихад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Монголбанкнаас зарласан ханш гэж тухайн өдөр Монголбанкны хаалтын ханшийг хэлнэ.
- 1.3. Монголбанкнаас зарласан хаалтын ханшийг дараа өдөр нягтлан бодох бүртгэлд хүчинтэй мөрдөнө.

**ХОЁР. БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ**

- 2.1 Банк нь дараах мэдээ, мэдээллийг тухайн өдрийн 16:40 цагаас өмнө Монголбанкны Зах зээлийн газар (цаашид ЗЗГ гэх)-ын Дотоодын зах зээлийн хэлтэс (цаашид ДЗЗХ гэх)-т [domex@mongolbank.mn](mailto:domex@mongolbank.mn) хаягаар хүргүүлнэ.

*/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-84 дүгээр тушаалаар өөрчилсөн./*

- 2.1.1 Өмнөх өдрийн 16:00 цагаас тухайн өдрийн 16:00 цагийн хооронд хийгдсэн ам.долларын арилжааны мэдээг бэлэн болон бэлэн бус арилжаа тус бүрээр энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу;
  - 2.1.2 Тавин мянган ам.доллараас дээш дүнтэй дэлгэрэнгүй арилжааны мэдээг энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу;
  - 2.1.3 Юаниар хийсэн арилжааны мэдээг энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу.
- 2.2 Банк нь ирүүлсэн мэдээ, мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцна.

**ГУРАВ. МОНГОЛБАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1 Монголбанкны ЗЗГ нь дор дурьдсан эрх, үүрэгтэй:

- 3.1.1.энэ журмын 2-т заасан мэдээлийг авах.
- 3.1.2.энэ журмын 2-т заасан үүргээ банк биелүүлж буй эсэхэд хяналт тавих.
- 3.1.3.энэ журмын заалтыг биелүүлээгүй банкинд хариуцлага ногдуулах

*/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-84 дүгээр тушаалаар өөрчилсөн./*

#### **ДӨРӨВ. ХЯНАЛТ**

- 4.1 Банк нь энэхүү журмын 2-т заасан мэдээ, мэдээллийг гаргах үүрэг бүхий ажилтан, түүнийг эзгүйд орлох нөөц ажилтны албан тушаалын нэр, цахим хаягийг албан бичгээр ЗЗГ-т хүргүүлэх ба албан тушаалтан өөрчлөгдсөн нөхцөлд ЗЗГ-т ажлын 2 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

*/Энэ заалтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А-84 дүгээр тушаалаар өөрчилсөн./*

- 4.2 Монголбанк нь энэ журмын 4.1 дэх заалтын дагуу мэдээллийн санд бүртгэгдсэн цахим хаягаас ирсэн мэдээллийг хүлээн зөвшөөрнө.
- 4.3 Банкны сүлжээ, системд саатал гарсан тохиолдолд банк нь энэ журмын 2-т заасан мэдээ, мэдээллийг факсаар эсвэл бичгээр ирүүлнэ. Энэ нөхцөлд зөвхөн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, банкны тэмдгээр баталгаажсан байна.

#### **ТАВ. ХАРИУЦЛАГА**

- 5.1 Энэхүү журмын 2-т заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг тухайн банк хариуцна.
- 5.2 Энэхүү журамд заасан мэдээ, мэдээллийг банк хугацаанд нь үнэн зөв ирүүлээгүй тохиолдолд Монголбанкны валютын улсын байцаагч холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээг тухайн банкинд авч хэрэгжүүлнэ.